



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/29

Баян-Өндөр сум

「Ажлын хэсгийн бүрэлдэхүүн томилох тухай」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын 2026 оны удирдах ажилтны чадавхижуулах сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ний өдөр зохион байгуулах, бэлтгэл ажил хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Сургалтын бэлтгэл ажлыг хангаж, үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн (М.Бямбасүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Ц МӨНХЦЭЦЭГ

ЭМГ-ын даргын 2026 оны 04 сарын 10-ны өдрийн
... 129 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



БЭЛТГЭЛ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

- Б.Уртнасан /УТХ-ын Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн/

Удирдан зохион байгуулах дэд хэсэг

- Гишүүд:**
- Д.Оюунтунгалаг / ХШХ-ын Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч/

- П.Хишгээ /ЭТҮХ-ийн Эмнэлгийн тусламжийн чанар, эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

- М.Бямбасүрэн / Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн/

- Н.Мөнгөнцацралт/ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн/

Техник, санхүү, туслах ажлын дэд хэсэг

- А.Хонгорзул / Анхан шат, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн/

- Б.Нямсүрэн / Цахим эрүүл мэнд, мэдээлэл технологи, кибер аюулгүй байдлыг хариуцсан мэргэжилтэн/

- Б.Будсүрэн / Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч/

- Г.Цолмонхүү / Эрүүл мэндийн медиа хөгжүүлэлт хариуцсан ажилтан/

- Ц.Намуундарь / Эрүүл мэндийн мэдээлэл түгээлт, олон нийттэй харилцах /

- Б.Алтанзагас / Нярав/

- Н.Мөнх-Ундраа / Архив бичиг хэргийн эрхлэгч /

Нарийн бичиг: Б.Ариунжаргал / Салбарын хүний нөөцийн төлөвлөлт хангалт, сургалт, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн/